



БАТСҮМБЭР СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан
Аймгийн Ерөнхий аудитор
өрөөний утас 70272582

Т.Майцэцэг - Ахлах аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Батсүмбэр сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Батсүмбэр сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Батсүмбэр сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн орлогыг 9962.4 мянган төгрөгөөр нэмж тодотгон 93466.7 мянган төгрөг болгосон ба гүйцэтгэлээр 114421.1 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 20954.4 мянган төгрөгөөр буюу 122.4 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Нэгтгэсэн тайланд ЗДТГазрын нэмэлт төсвийн санхүүжилтээр 42369.1 мянган төгрөгийг илүү нэгтгэсэн алдааг аудитын явцад залруулсан болно.
- СХСангаас 13 иргэнд олгосон үндсэн зээлийн 32124.2 мянган төгрөг, хүүгийн 1758.4 мянган төгрөг нийт 33882.6 мянган төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй байна. 2012 оны жилийн эцсийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар **Ерөнхий аудитор** т с а н а л о р у у л с а н б а й г а а

- ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.24 -ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.22

Танилцуулга

Батсүмбэр сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Батсүмбэр сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Батсүмбэр сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Батсүмбэр сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Батсүмбэр сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Батсүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 83504.3 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХУрлын 2013.07.05-ний өдрийн 02-р тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг 9962.4 мянган төгрөгөөр нэмж тодотгон 93466.7 мянган төгрөг болгосон байна. Тайлант онд гүйцэтгэлээр 114421.1 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 20954.4 мянган төгрөгөөр буюу 122.4 хувиар давуулан биелүүлсэн байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого буюу ЗДТГазрын 677.4 мянган төгрөг нь ЗДТГазрын харилцах дансаар төвлөрсөн мэдээ тайланд нэгтгэгдсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 20826.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд орлогын 1517899.5 мянган төгрөгийн, зарлагын 1509173.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдэж жилийн эцэст 29552.5 мянган төгрөгийн үлдэгдэл орон нутгийн төсвийн 140200910 тоот дансанд байна.

Орлогыг нэр төрлөөр тоцоход:

Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 114421.1 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 204795.5 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 1637553.3 мянган төгрөг, ОНХСанд аймгийн төсвөөс 143765.0 мянган төгрөг,

БХСанд 12000.0 мянган төгрөг, халамжийн санхүүжилт 409524.9, ХЭДСангаас СХСанд 75000.0 мянган төгрөг нийт 2597059.8 мянган төгрөг төвлөрсөн байна.

Төрийн сангийн шилжүүлгээр санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 115859.0 мянган төгрөг, ИТХуралд 43573.4 мянган төгрөг, Багт 45363.1 мянган төгрөг нийт 204795.5 мянган төгрөгийн санхүүжилтийг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазар 105017.2 мянган төгрөгийг олгосон байна. БХСанд 12000.0 мянган төгрөг, ОНХСанд 143765.0 мянган төгрөг тус тус олгогдсон байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 963893.7 мянган төгрөг, Цэцэрлэгт 347866.7 мянган төгрөг, Эмнэлэгт 271926.6 мянган төгрөг, Соёлын төвд 53866.3 мянган төгрөг, нийт 1637553.3 мянган төгрөг шилжүүлсэн ба дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 37285.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

СТСХэлтсийн шийдвэрээр ЕБСургуулийн хоолны зардлын хэмнэлт 15108.9 мянган төгрөгийг 2013.12.24-ний өдөр Баянчандмань ЕБСургуулийн дутагдсан зардалд шилжүүлсэн байсныг Батсүмбэр сумын ЕБСургуулийн санхүүжилт $963893.7 - 15108.9 = 948784.8$ мянган төгрөгөөр нэгтгэж, хоолны зардлыг **15108.9** мянган төгрөгийг бууруулсан байна.

Халамжийн сангийн санхүүжилт 409524.9 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 309740.6 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 83729.3 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 14370.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 1685.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 9675.5 мянган төгрөг, Сургууль 5738.3 мянган төгрөг, ЭМТөв 240.8 мянган төгрөг, Цэцэрлэг 2000.0 нийт 17654.6 мянган төгрөгийг орлого, 17440.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 214.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан ба нэгтгэлд ЗДТГазрын нэмэлт төсвийн санхүүжилтээр 42369.1 мянган төгрөгийг илүү нэгтгэсэн байна. Сумын нэгдсэн тайланд илүү нэгтгэсэн 42369.1 мянган төгрөгийг залруулсан болно.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 677.4 мянган төгрөг, Соёлын төв 1108.7 мянган төгрөг, ЭМТөв 690.0 мянган төгрөг, Сургууль 316.0 мянган төгрөг, нийт 2792.1 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Сум Хөгжлийн Санд 75000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 7058.0 мянган төгрөг, ИТХурал 79.3 мянган төгрөг, Баг 168.3 мянган төгрөг нийт 11484.3 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 178658.4 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 20826.1 мянган төгрөг, эм эргэлтийн сан 12775.1 мянган төгрөг нийт 219565.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 177000.5 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 29552.5 мянган төгрөг, эм эргэлтийн сан 14683.0 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 214.3 нийт 221450.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 79200.9 мянган төгрөгийн авлага, оны эцэст 240677.5 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 161476.6 мянган

төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 230333.1 мянган төгрөгийн буюу 95.7 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөгө оны эхэнд 3549.4 мянган төгрөг, оны эцэст 34302.3 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эхнээс 30752.9 мянган төгрөгөөр өссөн байна. Оны эхнээс өр өссөн гол шалтгаан нь СХСанд аймгийн Хөрөнгө төвлөрүүлэх орлогот шилжүүлэх 30952.0 мянган төгрөгийг өглөг үүсгэсэнтэй холбоотой байна. ЭЭСангийн жилийн эцсийн өглөг 2991.0 мянган төгрөг тус тус эзэлж байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 173912.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 367602.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 394183.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 147331.7 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 5844289.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 102900.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 49471.1 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 5897719.1 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 190078.2 мянган төгрөг үлдэх өртөг 3835399.0 мянган төгрөг байна

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Сум хөгжүүлэх сан

2012 оны жилийн эцсээр 27 хүнд 71557.3 мянган төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэл, 807.8 мянган төгрөгийн хүүгийн үлдэгдэлтэй, нийт зээлийн авлага 72365.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2013 оны эхний үлдэгдэл зээлийн авлагаас 18 хүний нийт 27740.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэйгээс 8 хүний 5195.2 мянган төгрөгийн материалыг шүүхэд өгч 2 хүний 1308.3 мянган төгрөгийн зээлийн үндсэн дүн, 31.0 мянган төгрөгийн зээлийн хүү төлөгдөн, 1 иргэн зээлийг хүүгийн хамт бүрэн төлж дууссан байна.

Тайланд онд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 75000.0 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн төрийн сангийн харилцахын 2012 оны жилийн эцсийн үлдэгдэл 166006.2 мянган төгрөг, нийт 241006.2 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэртэйгээс 2013 онд шинээр 26 иргэн, 1 хоршоонд нийт 205500.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна. Нийт олгосон зээлээс 2013 онд нийт үндсэн зээлийн дүнгээс 47771.1 мянган төгрөг, зээлийн хүүгээс 3849.6 мянган төгрөг нийт 51620.6 мянган төгрөгийн зээл төлөгдсөн байна. 2013 оны жилийн эцсээр үндсэн зээлийн үлдэгдэл 229286.2 мянган төгрөг, төлбөл зохих зээлийн хүүгийн хэмжээ 1176.0 мянган төгрөг, нийт 230462.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс хугацаа хэтэрсэн 13 иргэнд олгосон үндсэн зээлийн 32124.2 мянган төгрөг, хүүгийн 1758.4 мянган төгрөг нийт 33882.6 мянган төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй байна. 2012 оны жилийн эцсийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тайланд онд сум хөгжүүлэх сангийн дансанд мянганы сорилтын сангаас худгийн үнийн эргэн төлөлт 573.6 мянган төгрөг орсон байна. Сум хөгжүүлэх сангаас зээлийн илүү төлөлтийн

буцаан олголт 52.5 мянган төгрөг, аудитын газраас эмнэлгийн машины түрээсийн орлого байршуулсан 200.0 мянган төгрөгийн акт бичигдсэнийг төлсөн байна.

ГХУСС-ийн тайлан

Тайланд онд ИТХ-ын ГХУСэргийлэх зардлын батлагдсан төсөв 3052.0 мянган төгрөгийг Батсүмбэр сумын ГХУССангийн дансанд орж олон нийтийн байцаагчид 350.0 мянган төгрөг, ГХУСАЗЗөвлөлийн 2013 оны 04 сарын 25-ний 02 тоот

тогтоолоор архи тамхигүй монгол хүн тэмцээнд оролцох зардалд 437.8 мянган төгрөгийн зардал, томилолтын зардалд 68.0, шатахуунд 714.9 мянган төгрөг, цагдаагийн машины сэлбэгт 1200.0 мянган төгрөг, эд хогшлийн зардалд 649.9 мянган төгрөгийн зардлыг тус тус зарцуулсан байна. Тэмцээний зардалд 165.0 мянган төгрөг, шатахуунд 837.0 мянган төгрөг,

Байгаль орчин хамгаалах сан

БОХамгаалах сан нь 2013 онд 12000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас санхүүжилтийг бүрэн авсан байна. Мөн морин эргүүлийн урамшуулалд 600.0 мянган төгрөг, Био техник арга хэмжээний зардалд 180.0 мянган төгрөг, бусад зардалд 1135.4 мянган төгрөг орж ирж нийт 13915.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан байна. 2013 оны 08-р сарын 12-нд Иргэн С.Мөнхбаттай 1000.0 төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан Мандал 1-р багт байршилтай 10 ширхэг хогийн савыг хийлгэж төлбөрийг 70, 30 хувиар хуваан төлсөн байна. Дээрх гүйцэтгэсэн ажлын 1000.0 мян.төг-өөс ХХОАТ-ын 10 хувийг суутган шилжүүлээгүй зөрчил илэрлээ. 2013 оны 10 сарын 24-нд хувь хүн Цэцэгжаргалаас худалдан авсан 1000.0 мянган төгрөгийн засварын материалаас татвар суутгаагүй байна. Морин эргүүлийн урамшуулалд 16 хүнд нийт 1200.0 мянган төгрөгөөс ХХОАТ суутгасан боловч НДШ суутгаагүй байна. Тайланд онд БОХСангаас 869.8 мянган төгрөгийн 2 ширхэг зургийн аппарат, 1600.0 мянган төгрөгийн 8 ширхэг аппаратыг байгаль хамгаалагч нартаа авч өгсөн байна. Эргүүл хяналтын шатахуунд нийт 3923.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Оны эхний үлдэгдэл 8263.9 мянган төгрөг, 13422.9 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, нийт 15314.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гаргаж 2013 оны жилийн эцсээр 6372.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Мал хамгаалах сан

Оны эхний үлдэгдэл 2412.4 мянган төгрөг, Төв мал хамгаалах сангаас 1000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, өвсний борлуулалтаар 4252.5 мянган төгрөг, хорголжин тэжээлийн борлуулалтаас 3470.2 мянган төгрөг, нийт 8722.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэн байна. Объект 3 буюу улсын тэжээлийн нөөцийн газраас 3260.0 мянган төгрөгийн хорголжин тэжээл, томилолтонд 106.5 мянган төгрөг, вагон тавилт болон бусад зардалд 243.6 мянган төгрөгийн тус тус зарлага гаргасан байна. 2013 оны жилийн эцсээр 7525.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. 8 хүнээс хорголжин тэжээлийн 618.5 мянган төгрөгийн авлага, өвсний 4 хүний 807.5 мянган төгрөгийн авлага, нийт 1368.8 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сан

Тайланд онд орон нутгийн иргэдээс авсан санал асуулгаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн 11 ажлын хүрээнд 249000.0 мянган төгрөг төсөвлөгдсөн байна. Гүйцэтгэлээр 143765.0 мянган төгрөгийн санхүүжилт сууж, Тендерийн материалын үнээр 290.0 мянган төгрөг тус тус орон нутгийн хөгжлийн сангийн дансанд орсон байна. Эрэмбэлэгдсэн ажлуудаас 6 ажил хийгдэж 69686.6 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд

1. Сумын төвийн гэрэлтүүлэг 49897.9 мянган төгрөг
2. Хогийн тээвэрлэлт, ажиллах хүчний зардалд 7347.5 мянган төгрөг
3. Сумын баяр наадмын зардал 6216.4 мянган төгрөг
4. Стадионы засвар үйлчилгээ 4013.5 мянган төгрөг
5. Гудамжны гэрэлтүүлгийн цахилгааны зардал 518.0 мянган төгрөг
6. Гудамжны гэрэлтүүлгийн урсгал засварт 1783.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2013 оны жилийн эцсээр 74368.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Эм эргэлтийн сангийн талаар:

Батсүмбэр сумын эм эргэлтийн сангийн 2013 оны жилийн эцэст Хаан банкны харилцах дансны үлдэгдлээр 13978.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, жилийн эцсийн кассын тооллогоор 704.3 мянган төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй ба нийт 14682.9 мянган төгрөгийн үлдэгдэл нь санхүүгийн тайланд тусгасан мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тохирч байна. Аудитын явцад програмаас мөнгөн гүйлгээний журнал хэвлэгдэхгүй байгаа учраас шалгалт хийхэд хүндрэлтэй санхүүгийн тайланд тайлагнагдсан дүнгүүд бодитой эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна. Тайланд тусгагдсан 2868.9 мянган төгрөгийн өглөгийг баталгаажуулсан тооцоо бодсон акт байхгүй боловч нягтлан бодогчийн тайлбараар тухайн газартай няраваа тооцоо нийлүүлэхээр явуулахад ямарч тооцоогүй өглөг авлага байхгүй гэсэн гэж тайлбар өглөө. 2013 оны тайланд хугацаанд Батсүмбэр сумын Эмнэлэг болон ЗДТГ-ийн нүүрсний үнэнд нийт 9751.5 мянган төгрөгийг эргэлтийн эмийн сангийн мөнгөнөөс шилжүүлэн авлга үүсгэж үүссэн авлагаас 395.9 мянган төгрөгийг дутуу авч авлагаар тайлагнасан байна. Эргэлтийн эмийн сангийн хөрөнгөөс 2013 оны 03 сарын 26-нд Батсүмбэр сумын эмнэлэгт 640.0 мянган төгрөгийн угаалгын машин худалдан авсан байна. Мөн 1310.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна. Тайланд онд эмийн санч нь хувь хүмүүст 3967.7 мянган төгрөгийн эмийг зээлээр өгч авлага үүсгэсэн байна. Бараа материалын тайлан гаргаагүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Тус сумын ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг байгууллагууд нь Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.
- ЭМТөв нь шатахуун, нүүрсний орлого, зарцуулалтын тайлан огт гаргаагүй, Нүүрсний тооцоог хийж байвал зохих үлдэгдлийг гаргахад санхүүгийн тайлангийн бараа материалын тайлангаар тайлагнасан үлдэгдэлтэй 3168.3 мянган төгрөгөөр

зөрсөн. Шатахуун олгохдоо зөвхөн ЭМТөвийн эрхлэгчийн цохолтоор олгогдож жолоочийн тооцооны хуудасны ирсэн явсан спидометрийн заалтыг бичээгүй, шатахуун зарцуулалт нягтлан бодогчоор хянагдахгүй, няравын дансаар дамжиж хийгдэхгүй байна. Ажиллагчидтай холбогдсон зардлыг мөнгөн гүйлгээний тайланд 211347.0 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд 208574.4 мянган төгрөгөөр буюу 2772.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан ба авлагын тайланд НДШ-ийн авлагаар тайлагнагдсан 742.2 мянган төгрөгийн авлагатай 2030.4 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс их байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлт өгөгдсөн

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Нярав эд хариуцагчийн тайланг тогтмол хийлгэж хэвших

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн Сумын нэгдсэн тайланд илүү нэгтгэсэн 42369.1 мянган төгрөгийг залруулсан болно.

Өмнөх зөвлөмж акт, албан шаардлагын хэрэгжилт

СХСангийн 2012 оны жилийн эцсийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тайлбар мэдүүлгийн захидал

1. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

2. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.21